

Төрийн албаны зөвлөлийн
2023 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн
61 дүгээр тогтоолын 28 дугаар хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
 Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт
оргуулах тухай 2021 оны 11 дүгээр сарын 12-
ны өдрийн хууль

Дагаж мөрдөх огноо:

2022 оны 01 дүгээр сарын 01

Албан тушаалын тодорхойлолтыг
баталсан огноо:

Байгууллагын нэр:

Гаалийн ерөнхий газар

Албан тушаалын нэр:

Хар тамхи, мөнгө угаахтай тэмцэх асуудал
хариуцсан гаалийн улсын байцаагч

Ажлын цаг

Ажлын өдөр 8 цаг

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Нэгжийн нэр:

Хар тамхи, мөнгө угаахтай тэмцэх хэлтэс

Албан тушаалын ангилал, зэрэглэл

Дэс түшмэл, ТТ-5

Ажлын байрны албан ёсны байршил:

14193 Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 8
дугаар хороо, Их тойруу 81-1

Онцгой нөхцөл:

Албан ажлын онцгой нөхцөлд хамаарна

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮФЭГ

Албан тушаалын зорилго:

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль
бус эргэлттэй тэмцэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмийт тэмцэх, таслан
зогсоох, урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, зөрчилд холбогдогчдын мэдээллийн нэгдсэн санг
бүрдүүлэх, мэдээлэл хүлээн авах, боловсруулах, дүн шинжилгээ хийх, онилж, илрүүлэх
ажиллагааг хэрэгжүүлж, Үндэсний хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан гаалийн
байгууллагын хариуцах ажлын хэрэгжилтийг хангаж, Гаалийн ерөнхий газрын зохион
байгуулалтын нэгж, дэргэдэх байгууллага, харьяа гаалийн газар, хороодыг мэргэжил, арга
зүйгээр хангах, хариуцсан албан хаагчдыг сургалтад хамруулах, мэргшүүлэх ажлыг зохион
байгуулж мэргшүүлэх үндсэн зорилгыг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг нэгжийн даргын өмнө
хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх үйл ажиллагаанд Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээр, стандарт, дотоодын хууль, тогтоомж, үндэсний хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг хангах;
2. Гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох шуурхай шалгах ажиллагааг хэрэгжүүлэх, илэрсэн гэмт хэрэг, зөрчилд хойшлуулшгүй ажиллагаа, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг мэргжил, арга зүйгээр хангах, үүрэг даалгавар, зөвлөмж хүргүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;
3. Мэдээлэл хүлээн авах, бүртгэн төрөлжүүлж сан үүсгэх, боловсруулах, дүн шинжилгээ хийх, тэдгээрт суурилсан гэмт хэрэг, зөрчлийг онилох илрүүлэх ажиллагааг хэрэгжүүлнэ;
4. Гадаадын улс орны болон үндэсний хууль хяналтын байгууллагуудтай хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлттэй тэмцэх болон мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хамтран ажилтаж, харилцан мэдээлэл солилцох эрх зүйн орчныг бүрдүүлж, хэрэгжилтийг хангах;
5. Харьяа гаалийн газар, хороодын хар тамхи, ма-сууруулах бодис болон хууль бус бэлэн мөнгө, валютыг илрүүлэх хяналт шалгалтын тсног төхөөрөмжийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, судалгаа хийж удирдлагад танилцуулах;
6. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэхтэй холбоотой хэрэг, зөрчлийн мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийх явцад гаалийн хэрэг, зөрчил үйлдэгдэж байж болзошгүй сэжиг, үндэслэл байгаа тохиолдолд гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ажлыг нэн даруй зохион байгуулсан байна.
7. Нэгжийн өдөр тутмын үйл ажиллагааны гүйцэтгэг, албаны шуурхай, бэлэн байдлыг хангах.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах-Т, Гүйцэтгэх-Г Хянах-Х Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний хэрэгжилтийг хангах;	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	X, Г
	2.Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний хэрэгжилтийг хангах;	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	X, Г
	3.НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1540 дугаар тогтоол, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх үндэсний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах;	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	X, Г
2 дугаар зорилтын	1.Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хяна- шийдвэрлэх тухай хуулийн хүрээнд хийгдэх хойшлуулшгүй ажиллагааг гүйцэтгэх;	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	X, Г 

хүрээнд	2.Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн хүрээнд хийгдэх ажиллагааг хэрэгжүүлэх;	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	X, Г
	3.Хар тамхи, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис, бэлэн мөнгө, валютын хууль бус эргэлт, мөнгө угаах гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох шуурхай ажиллагаа, арга хэмжээг гүйцэтгэх;	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	X, Г, Т
	4.Албан хаагчдыг хар тамхи, мансууруулах бодис, бэлэн мөнгө, валютын хууль бус эргэлт, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, стратегийн болон хоёрдмол зориулалттай барааны хяналтыг хэрэгжүүлэх, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчил илрүүлэх чиглэлээр мэргэшүүлэх сургалтыг хэрэгжүүлэх;	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Г, Т
	5.Хамтын ажиллагаатай төрийн болон төрийн бус байгууллага, гаалийн харилцаанд оролцож буй аж ахуйн нэгжүүдэд хар тамхи, мансууруулах бодис, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, стратегийн болон хоёрдмол зориулалттай бараатай холбоотой сургалт, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх.	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Г, Т
	1.Хар тамхи, мансууруулах бодис, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, стратегийн болон хоёрдмол зориулалттай бараатай холбоотой гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэн төрөлжүүлж, гэмт хэрэг, зөрчилд холбогдогчдын мэдээллийн төрөлжсөн сан үүсгэх, гомдол мэдээллийг шалгаж шийдвэрлэх ажлыг гүйцэтгэх;	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Г, Т
3 дугаар зорилтын хүрээнд	2.Хар тамхи, мансууруулах бодис, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, стратегийн болон хоёрдмол зориулалттай бараатай холбоотой гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг тогтоох, судалгаа дүн шинжилгээ хийх ажлыг гүйцэтгэх.	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	



4 дүгээр зорилтын хүрээнд	1.Дэлхийн гаалийн байгууллага, бус нутгийн гаалийн зөрчлийн мэдээлэл солилцох албатай үндэсний холбоо баригч томилон хууль сахиулах олон улсын хамтарсан арга хэмжээнд оролцох ажлыг гүйцэтгэх;	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Г, Т
	2.БНХАУ, ОХУ болон бусад улс орны гаалийн байгууллагуудтай хууль сахиулах чиглэлээр хамтран ажиллах, харилцан мэдээлэл солилцох ажлыг хэрэгжүүлэх;	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Г, Т
	3.Дотоодын хууль, хяналтын байгууллагуудтай хууль сахиулах чиглэлээр хамтран ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлж, харилцан мэдээлэл солилцох ажлын хэрэгжилтийг хангах.	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Г, Т
5 дугаар зорилтын хүрээнд	1.Харьяа гаалийн газар, хороодын хартамхи, мансууруулах бодис болон хууль бус бэлэн мөнгө, валютыг илрүүлэх хяналт шалгалтын тоног төхөөрөмжийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, судалгаа хийх ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, удирдлагад танилцуулах;	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Г, Т
	2.Хууль бус бэлэн мөнгө, валют илрүүлэх, мөнгө угаахтай тэмцэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх, терроризмтой тэмцэх чиглэлээр гаалийн хяналт шалгалтад ашиглах дэвшилтэй тоног төхөөрөмж, арга ажиллагааг нэвтрүүлэх чиглэлээр судалгаа хийж, удирдлагад танилцуулах;	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Г, Т
6 дугаар зорилтын хүрээнд	1.Чиг үүргийн хүрээнд цугларсан мэдээлэлд дүн шинжилгээ хийх явцад гаалийн хэрэг, зөрчил үйлдэгдэж байж болзошгүй сэжиг, үндэслэл байгаа тохиолдолд гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ажлыг нэн даруй гүйцэтгэх;	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Г
	1.Байгууллагын чиг үүрэг, стратеги төлөвлөгөөтэй уялдуулан нэгжийн үйл ажиллагаанд эрсдэл тооцож, нэгжийн төлөвлөгөөний төслийг боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг хангах, тайлагнах;	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн	Г
	2.Нэгжийн өдөр тутмын үйл ажиллагаа, албаны шуурхай, бэлэн байдлыг хангах, ажил үүргийн хуваарийн төслийг гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан жил бүр, шаардлагатай тохиолдолд тухай бүр гарган,	Нэгжийн өдөр тутмын үйл ажиллагаанд ажил үүрэг давхцахгүй, орхигдохгүй байхаар төлөвлөгдсөн байна	Г 

7 дугаар зорилтын хүрээнд	удирдлагад танилцуулж батлуулах хэрэгжилтийг хангах;		
	3. Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага, харьяа гаалийн газар, хороодыг удирдамж чиглэлээр хангаж, үүрэг даалгавар, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, хяналт тавих, сургалт зохион байгуулах;	Удирдамж, чиглэлийн тоо, үр дүн	Г
	4. Төрийн албаны тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд төрийн албан хаагчийн албаны үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн зарчим, манлайллыг удирдлага болгон ажиллах;	Төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэсэн байна	Г
	5. Архив, албан хэрэг хөтлөлтийн заавар, журам, стандартад нийцсэн баримт бичгийн төсөл төлөвлөх, архивын нэгж бүрдүүлэх ажлыг хэрэгжүүлэх;	Албан хэрэг хөтлөлтийн заавар, журам, стандартад нийцсэн байна	Г
	6. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь биелүүлэх, олон нийтийг хамруулсан арга хэмжээ зохион байгуулах, оролцох, хамт олныг хамруулах.	Хамт олныг хамруулсан зохион байгуулсан арга хэмжээ, хурал, цуглааны тоо, үр дүн	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх		
Мэргэжил	<ul style="list-style-type: none"> - Эрх зүй (0421), - аюулгүй байдлыг хангах (103), - хими (0531), - худалдаа (0416). 		
Мэргэшил	Төрийн албанад мэргэшүүлэх зохих багц сургалтад хамрагдаж төгссөн байх.		
Туршлага	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.		
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх ур чадвар	<ul style="list-style-type: none"> - мэдээллийн үнэн, бодит байдлыг шалган нягтлах; - нарийн төвөгтэй мэдээллийг шинжилж, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тодруулах; - байгууллагын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг илрүүлэх; - судалгааны арга зүйн мэдлэгтэй байх, харьцуулсан судалгаа хийх; - албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулах; - мэдээлэлд тулгуурлан хууль тогтоомжийн дагуу тодорхойлсон чиг үүргийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ, хийх; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах. 	МОНГОЛ УЛС ДАЧИАЛГААНЫ АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА ЗААНЫ СОХИЛСАН

	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> - сэтгэн бодох, анализ хийх, хөрвөх чадвартай байх; - өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах; - албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд асуудлыг хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн, ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - албан тушаалын чиг үүргийн хүрээнд гаргасан шийдвэрийнхээ үр дагаврыг хариуцах; - асуудал шийдвэрлэх эдийн засаг, хууль зүйн үндэслэлийг тодорхойлох; - удирдлагын өгсөн чиглэлийн дагуу байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээг зохион байгуулах; - өөрийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавьж чаддаг.
	Багаар ажиллах	<ul style="list-style-type: none"> - өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах; - бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох; - багаар ажиллах, багийн амжилтыг үнэлэх, дэмжих, бусдад таниулах.
	Бусад	<ul style="list-style-type: none"> - албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах; - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах; - гадаад худалдаа, гаалийн хөгжлийн чиг хандлагаас суралцан, өөрийгөө хөгжүүлэх; - төрийн албан хаагчийн болон гаалийн улсын байцаагчийн ёс зүйн хэм хэмжээ, үйлчилгээний стандарт, сахилгын тусгай дүрмийг чанд сахин ажиллах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх; - монгол хэл бичгийн мэдлэгийн төвшин нь албан ажлын шаардлагыг хангасан; - харилцааны орчин үеийн арга хэлбэрийг ашиглан, гаалийн харилцаанд оролцогчидтой харилцах.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:

Хар тамхи, мөнгө угаахтай тэмцэх хэлтсийн дарга, Хар тамхи, мөнгө угаахтай тэмцэх хэлтсийн гаалийн улсын ахлах байцаагч

<u>Албан тушаалд шууд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</u>	<u>Бусад харилцах субъект:</u>
	<ul style="list-style-type: none"> - Төрийн болон төрийн бус байгууллагын холбогдох ажилтан; - Иргэн, хуулийн этгээд; - Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага, харья гаалийн газар, хорооны дарга, албаны дарга, салбарын эрхлэгч, гаалийн улсын ахлах байцаагч, гаалийн улсын байцаагч, бусад ажилтан.

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:



Албан тушаал:

ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Ч.ТАМИРАА (Гарын
үсэг) (Эцэг/эх-/ийн нэр, өөрийн нэр)

20~~0~~0~~0~~ оны 9 сарын 11-ны өдөр

Байгууллагын нэр:

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Шийдвэрийн

огноо: 23 0309

Дугаар: 061

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр:

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

Шийдвэрийн огноо:

Дугаар:

(тамга/тэмдэг)

ДАРГА..... Р.ОТГОНЖАРГАЛ

(Гарын үсэг) (Эцэг/эх-/ийн нэр, өөрийн нэр)
20~~0~~0~~0~~ оны 10 дугаар сарын 11-ны өдөр

